



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 8/222

Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 2.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Багахангай Дүүргийн менежерийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Албан тушаалын тодорхойлолтыг албан хаагчид танилцуулан, хувийн хэрэгт хавсаргахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Огтонжаргал)-т үүрэг болгосугай.

3. Албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан Дүүргийн Засаг даргын Албан тушаалын тодорхойлолт батлах тухай 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/110 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дуургийн Засаг даргын
2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн дугаар
захирамжийн хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ҮЛГЭРЧИЛСЭН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Хууль тогтоомжийн нэр огноо:

ЗГ-ын 2024 оны 81-р тогтоол

Дагаж мөрдөх огноо:

2024.12.26

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо

Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 26-
ны А/222 дугаар захирамж

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Багахангай дуургийн Засаг даргын
Тамгын газар

Удирдлага

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дүүргийн менежер

УТ

Ажлын цаг

Ажлын байрны албан ёсны байршил

Ажлын өдөр 8 цаг

Улаанбаатар хот Багахангай дүүрэг
1 дүгээр хороо ЗДТГ-ын байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай, Хог хаягдлын тухай, Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, нийслэл, дуургийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан барилга байгууламж, авто зам, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, гэрэлтүүлэг болон бусад дэд бүтцийн засвар, арчлалт, цэвэрлэгээ, үйлчилгээ, арчлалт хамгаалалт, ариутгал, хог хаягдлын менежмент, хүнс, худалдаа үйлчилгээ зэрэг хот, нийтийн аж ахуйн ажил үйлчилгээг Дуургийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үзүүлэх ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар ханган гүйцэтгэлийн үр дүнг Дуургийн Засаг дарга болон Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай, Хог хаягдлын тухай, Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хангах ажлыг удирдан зохион байгуулах, ажлын үр дүнг сайжруулах чиглэлээр санал, зөвлөгөө өгөх.
2. Дүүргийн нутаг дэвсгэрт барилга байгууламж, авто зам, үерийн хамгаалалтын барилга байгууламж, нийтийн эзэмшлийн зам талбай, тохижилт, ногоон байгууламж, гэрэлтүүлэг болон бусад дэд бүтэц, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн арчлалт хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдвартгүйтгэл зэрэг хотын аж ахуйн үйлчилгээг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх, хамтран ажиллах, нэгдсэн удирдлагаар хангах, тайлагнах, сурталчлах.
3. Дүүргийн нутаг дэвсгэрт эзэнгүй нохой, муурын тоо толгойг бууруулах, хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх ажлыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран үзүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, тайлагнах, сурталчлах.
4. Дүүргийн нутаг дэвсгэрт хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлийн бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, бүртгэлжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, тайлагнах, сурталчлах
5. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах-Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд заасан Дүүргийн Засаг даргын болон Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж, Хотын Ерөнхий менежерийн шуурхай зөвлөгөөнөөс болон цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, ажлаа тайлагнах.	Хууль тогтоомж, эрх бүхий албан тушаалтын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, албан тушаалын тодорхойлолтод заасан үүргээ хэрэгжүүлсэн байх	Г, Х, Ш
	2. Эрхэлсэн ажлын хүрээнд хотын аж ахуйн салбарын чиглэлээр гарсан хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг орон нутагт хэрэгжүүлэх, хяналт тавих, үр дүнг тайлагнах,	Хуулийн хүрээнд хэрэгжилтийг хангасан байх.	Г, Х, Ш
	3. Дүүргийн хүн ам, оршин суугчдын эрүүл аюулгүй, тав тухтай, цэвэр орчинд ажиллах, амьдрах нөхцлийг хангах хүрээнд бодлогын баримт бичгүүд, төсөв, хөрөнгө оруулалтын төсөлд санал тусгуулах, батлагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах.	Өгсөн санал, гүйцэтгэл, чанар, хэрэгжилтийн хувь хэмжээгээр хэмжигдэнэ.	Х, Г
	4. Чиг үүргийн хамаарал бүхий Дүүргийн Тамгын газрын дотоод хэлтэс (ТНААХ, ХХҮХ) болон Мэргэжлийн албад, нэгжүүдийг (Дүүргийн цагдаа, онцгой байдал, хяналтын байгууллага, татвар, Хороод) удирдлага зохицуулалтаар хангах, хагас бүтэн жилээр ажил дүгнэхэд оролцох, санал дүгнэлт өгөх.	Эрх зүйн чадамжийн хүрээнд ажлын гүйцэтгэл, үр дүн сайжирсан байна	Х, Ш

	<p>5.Хотын аж ахуйн үйл ажиллагаанд оролцож буй мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, ажил үүргээ уялдуулах. Үүнд: Инженер хангамжийн байгууллагууд, УБ хотын Шуурхай удирдлага зохицуулалтын төв, бусад Дүүргүүд, Монголын сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөл, Хувийн орон сууцны холбоод гэх мэт.</p>	<p>Ажлын уялдаа холбоог хангасан, иргэд оршин суугчдын гомдол, хүсэлтийн шийдвэрлэлт, чанар үр дүнгээр хэмжигдэнэ.</p>	X, Г
	<p>6.Аж ахуйн ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж буй төсөвт болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудыг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, үнэлэх, дүгнэх үйл ажиллагаанд оролцож, үүрэг даалгавар өгөх, хэрэгжилт үр дүнг тооцох, хяналт тавих, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, ажил үүргийг уялдуулан зохицуулах.</p>	<p>Эрх зүй, эдийн засгийн чадамж сайжирч, ажлын уялдаа холбоо, үр дүн сайжирсан байна.</p>	X, Ш
	<p>7.Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, хог тээвэрлэх, үйлчилгээ үзүүлэх болон хотын аж ахуйн чиглэлээр байгуулсан гэрээнүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцох ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах.</p>	<p>Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдаж байгаагаар илэрхийлэгдэнэ</p>	X, Ш
	<p>8.Дүүргийн Ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, газар зохион байгуулалтын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах</p>	<p>Хуулийн хүрээнд хэрэгжилтийг хангасан байна</p>	Г.Х,Ш
2 дугаар зорилтын хүрээнд	<p>1.Дэд бүтэц, инженер хангамжийн шугам сүлжээ, тоноглолуудын бүрэн бүтэн аюулгүй байдалд хууль тогтоомжоор олгогдсон эрх, үүргийн хүрээнд хяналт хэрэгжүүлж, мэргэжлийн албад, ашиглагч байгууллагуудтай хамтран ажиллах, зөрчил арилгуулах ажлыг зохион байгуулах.</p> <p>Үүнд: Худгийн таг, үерийн хамгаалалтын барилга байгууламж, борооны болон ус зайлцуулах шугам, цэвэр, бохир усны шугам сүлжээ, агаарын болон шилэн кабель, лифт, гүүрэн байгууламж, хайс хашилага, тэмдэг тэмдэглэгээ болон бусад.</p>	<p>Иргэд, оршин суугчдын эрүүл, аюулгүй, тав тухтай орчин хангагдсан, сэтгэл ханамжийн түвшингээр илэрхийлэгдэнэ</p>	Г,Х,Ш
	<p>2.Нийтийн эзэмшлийн болон орон сууц гэр хороолол, орон сууц, бичил тохижилтын гэрэлтүүлэг, камержуулалт, тэдгээрийн байгууламж (дэд станц, кабель, удирдлагын шит гэх мэт) гэрлэн чимэглэлүүдийн хэвийн найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг хангуулах, шаардлагатай төсвийг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах, ашиглагч, хариуцагч (төсөвт болон гэрээт байгууллага, СӨХ, хувийн орон сууцны контор) байгууллагуудын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж. үү дунг</p>	<p>Иргэд, оршин суугчдын эрүүл, аюулгүй, тав тухтай орчин хангагдсан, сэтгэл ханамжийн түвшингээр илэрхийлэгдэнэ</p>	Г,Х,Ш

	тооцох.		
	3. Нийтийн эзэмшилийн гудамж талбай, орон сууц, гэр хороолол, СӨХ, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллагуудын орчны 50 метрийг Хот, нийслэл, дүүргийн төлөвлөлтийн бодлоготой уялдуулан тохижуулах, дүрэм, журам норм стандартын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, сурталчлах	Иргэд, аж ахуй нэгж байгууллага, оршин суугчдын эруул, цэвэр, аюулгүй орчныг бүрдүүлсэн, сэтгэл ханамжийн үр дүнгээр илэрхийлэгдэнэ	Г,Х,Ш
	4. Тохижилтын хүрээнд бий болсон бичил тохижилт, нийтийн эзэмшилийн эд хөрөнгийг бүртгэлжүүлэх, арчлалт хариуцсан байгууллагуудыг эзэнжүүлэх, мэдээллийн сан үүсгэх, шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэх. Үүнд: Бичил тохижилт, цэцэрлэгт хүрээлэн, хуухдийн тоглоом болон спорт, ахмадын чийрэгжүүлэлтийн талбайнууд, хөшөө дурсгал, архитектурын жижиг байгууламж, усан оргилуур, сандал хогийн сав, автобусны буудал, гэрэлтүүлэг, явган болон дугуйн зам, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих зам, шат болон бусад.	Өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт арчлалттай холбоотой хууль журмын хэрэгжилт, эзэмшил ашиглалтын чанаар, хугацаа уртассан, орчны аюулгүй байдал хангагдсанаар илэрхийлэгдэнэ	Г,Х,Ш
	5. Ногоон байгууламжийн мастер төлөвлөгөө, Тэрбум үндэсний хөдөлгөөний хүрээнд нийтийн эзэмшилийн болон хязгаарлагдмал, тусгай хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, айл өрх, аж ахуй нэгжүүдийг мод тарих хөдөлгөөнийг идэвхижүүлэх, мэргэжлийн байгууллагаар агротехнологийн дагуу арчлалт хийлгэх, шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бий болгох, баяжуулах ажлыг зохион байгуулах.	Иргэд, оршин суугчдын эруул, тав тухтай орчин хангагдсан, сэтгэл ханамжийн түвшингээр илэрхийлэгдэнэ	Г,Х,Ш
	6. Гадна зар сурталчилгаа, хаяг хаягийн байгууламжид тавигдах шаардлага, хууль тогтоомж, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж зөрчил арилгуулах арга хэмжээг холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай хамтран зохион байгуулах	Иргэд, оршин суугчдын эруул, аюулгүй, тав тухтай орчин хангагдсан, сэтгэл ханамжийн түвшингээр илэрхийлэгдэнэ	Г,Х,Ш
	7. Алслагдсан дүүргүүдэд уул уурхай, үйлдвэрлэл инноваци, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалт, нийтийн тээврийг хөгжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллах холбогдох хуулийн хэрэгжилтийг хангуулах;	Хуулийн хүрээнд хэрэгжилтийг хангасан байна	Г, Х, Ш
	8. Алслагдсан дүүргүүдэд байгаль орчин, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн чиглэлээр тэр засаг, нийслэлээс	Хуулийн хэрэгжилтийг ханган	Г, Х, Ш

	баримтлах бодлогыг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх.	ажилласан байна.	
3 дугаар зорилтын хүрээнд	1.Хог хаягдлын менежментийг сайжруулах хүрээнд салбарын хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдүүлэх, үр дүнг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авах. Үүнд: Зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, энгийн хог хаягдлын цуглувалт, ангилан ялгалт, тээвэрлэлт, гудамж талбайн ариутгал, халдвартгуйжүүлэлт, нохой муурыг бүртгэлжүүлэх, тоо толгойг бууруулах гэх мэт.	Хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүн, иргэд оршин суугчдын гомдол, хүсэлтийн шийдвэрлэлт, чанар үр дүн, сэтгэл ханамжийн хэмжигдэнэ.	X,Г
	2.Агаар, орчин, хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах.	Хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүн, иргэд оршин суугчдын эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлсэн, сэтгэл ханамжийн үр дүнгээр илэрхийлэгдэнэ	Г, Х, Ш
	3.Хяналтын Төрийн бус байгууллагуудын ажилд хяналт тавьж, чиг үүргээр хангаж ажиллах	Ажлын гүйцэтгэл, чанар сайжирсан байна	X
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Дүүргийн худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөлийг удирдаж хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, салбарын хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах.	Холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулсан байна.	Г, Х
	2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой асуудлаар Дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг ахалж, холбогдох хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг хангуулах.	Холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулсан байна.	Г, Х
	3.Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй худалдаа, үйлдвэр, үйлчилгээний газруудыг нийслэлийн мэдээ, мэдээллийн цахим портал Онлайн бизнес төвийн "Үйлчилгээ эрхлэх бүртгэл"-ийн системд бүртгэлжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулалт хийх, хянан баталгаажуулах, ажлаа тайлагнах, сурталчлах	Мэдээллийн бүрэн, бодит байдал хангагдсан байна	Г,Х,Ш

	1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг чанд сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, эрх, үүргийг хэрэгжүүлэх;	Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, ил тод байдлыг хангана.	Г
5 дугаар зорилтын хүрээнд	2.Хотын аж ахуйн чиглэлээр байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;	Хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна.	X
	3.Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;	Стандарт хангагдсан байна.	X, Ш

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	<p>-Эрх зүй /042101, 042103/</p> <p>-менежмент ба удирдахуй /0413, 041304, 04130, 041305-041309/;</p> <p>-терийн захиргаа</p> <p>-эдийн засаг /0311/;</p> <p>-санхүү /041201/;</p> <p>-хүрээлэн буй орчин /052102/, хүрээлэн буй орчны инженер /071201/</p> <p>-инженерчлэл, инженерийн үйлдвэрлэл /071/;</p> <p>-үйлдвэрлэл, боловсруулалт /072/;</p> <p>-архитектур ба барилга угсралт /073/;</p> <p>-барилгын инженер /073204/;</p>		
Мэргэшил	Төрийн удирдлагаар мэргэшсэн байх. Чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн бол давуу тал болно.		
Туршлага	Удирдах албан тушаалд З-аас доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - нийслэл, дүүргийн хөгжлийн бодлого төлөвлөлтийг стратегийн түвшинд төлөвлөж хэрэгжүүлэхэд санал байр сууриа тусгаж, тулгамдсан асуудал шийдвэрлэгдэхэд нэлөөлөх; - үйл ажиллагааг төлөвлөх, бодлогын шийдвэрт тусгуулах, санхүүжилтийг шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх, дүгнэх, тайлгах; - нийгмийн болон иргэд оршин суугчдын эрх ашиг, одоогийн болон ирээдүйн хэрэгцээ шаардлагыг урьдчилан харж, стратегийн урт хугацааны зорилтыг тооцох, төлөвлөлтед тусгуулах, хэрэгжүүлэх; - мэргэжлийн албад, гэрээт байгууллагууд, албан хаагчдын ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, заавар чиглэл өгөх, санал, бодлыг сонсох, бүтээлч санаа, зөв хандлагыг дэмжих - орон нутгийн хөгжил шинэчлэлт өөрчлөлтийг иргэд, оршин суугчдын байр сууринаас харж, сөрөг нэлөөг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах; - гадаад, дотоод түншүүдтэй үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх; - хууль тогтоомж, эрх зүйн орчныг судалж, ажилдаа мөрдлөг болгох, сурталчлан таниулах, хамтдаа хөгжих боломжийг бурдуулэх; - үйл ажиллагаан дахь эрсдэлийг урьдчилан тодорхойлох, илрүүлэх, авах арга хэмжээний төслийг боловсруулах, танилцуулах; 	

		<ul style="list-style-type: none"> - ажил гүйцэтгэгчдийн санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих; - ажил гүйцэтгэгчид, алба хаагчдын сургалт хөгжил, материаллаг бааз суурийг бэхжүүлэхэд идэвхтэй дэмжлэг үзүүлж, үйл ажиллагаа бойжих, тогтворжих нөхцлийг бодлогоор дэмжих, хөгжүүлэх; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - гүйцэтгэлийг цаг тухайд нь үнэлдэг байх; - бусад.
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - аливаа асуудлын талаар бүрэн ойлголт авахын тулд шаардлагатай мэдээллийг цуглуулах, сонсох, үнэлэх, дүгнэх; - хоорондоо шууд хамааралгүй нөхцөл байдлын байж болох уялдаа холбоог тодорхойлдог байх; - болзошгүй үр дагаврыг урьдчилан таамаглаж, үйл ажиллагааны боломжит хувилбарыг төлөвлөдөг байх; - мэдээлэлд тулгуурлан чиг үргийн болон системийн шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа хийх; - судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан бодлого боловсруулах; - судалгааны үр дүн, шийдлийн хувилбарын шууд ба шууд бус үр дагаврыг харьцуулан үнэлж, зөвлөмж боловсруулах; - бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - Дуургийнхээ алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл, хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэр гаргах - аливаа харилцааг зохицуулах арга замыг хууль, тогтоомжийн төсөлд санал өгөх; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - аливаа шийдвэрийг гаргахдаа хамтрагч, хэрэгжүүлэгч байгууллага, хуулийн этгээд, хамт олны саналыг тусгадаг байх; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> - ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэрлэх; - үйл ажиллагаанд шинэлэг санаа, дэвшилтээ арга барил, үйлчилгээг нэвтрүүлэх, чиглүүлэх, албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч сэтгэлгээ, хандлагыг дэмжих; - үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг салбарын болон байгууллагын хамт олондоо тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх; - төлөвлөгөөнд аж ахуйн салбарын тулгамдсан асуудал, хамт олны саналыг тусгах, үр дүнд чиглүүлэх; - өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх; - нээлттэй, шударга байх; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх; - бусад.

	Бусад	<ul style="list-style-type: none"> - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусадад таниулах; - байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах; - харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглан мэдээллийг түгээх; - кирил болон үндэсний бичгээр албан бичиг боловсруулах, хянах, зөвлөх чадвартай байх.
--	-------	--

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Дүүргийн Засаг дарга.

	<p><u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс (тасагтайгаа); 2. Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс (тасагтайгаа). 	<p><u>Бусад харилцах субъект:</u></p> <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн нутгийн захиргааны удирдах дээд байгууллага, эрх бүхий албан тушаалтууд, - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, инженер хангамжийн болон мэргэжлийн байгууллагууд - Дүүргийн орон нутгийн өмчтэй аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, мэргэжлийн албад, хэлтэс; - хувийн хэвшлийн аж ахуй нэгж, байгууллага, иргэн, СӨХ, хувийн орон сууцны контор, Төрийн бус байгууллага, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй худалдаа, үйлчилгээний байгууллагууд;
--	--	--

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</u>
<p><u>Албан тушаал:</u></p>  <p>ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА <i>Л.Санжийжамц</i> (L.SANJIIJAMC) ХРЧ4344 9030018342 1853129</p>	<p><u>Байгууллагын нэр:</u></p>  <p>ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА <i>А.Сүхболд</i> (A.SUHBOLD) ШИЙДВЭРИЙН ОГНОО Дугаар: (тамга/тэмдэг)</p>

2024 оны 12 дугаар сарын 26.-ны өдөр

2024 оны ... дугаар сарын ... -ны өдөр